



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Онги-Ус суваг” /ТБОНӨО/ ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2026/02/НА-СТА-ОНӨҮГ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2026 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn Аудитын менежер: П.Хорлоосүрэн Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

Шал. 03.13 № 138
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Онги-Ус суваг” /ТБОНӨО/ ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Онги-Ус суваг” /ТБОНӨО/ ХХК-ийн 20245 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бидний хэрэгжүүлсэн горим сорилоор бараа материалын дансны үлдэгдэл, ангилал, хуваарилалт, бараа материалын зарцуулалттай холбоотой 156.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т “Тооллогын комисс дараах үүрэгтэй” 4/1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 73 дугаар зүйлийн 2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна. Санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Оршин байх” зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2025.02.10

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус компани нь тайлант онд 3,572.9 сая төгрөгийн борлуулалтын орлого, орон нутгийн төсвөөс 373.6 сая төгрөгийн татаас авч, нийт 3,946.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,737.0 сая төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт, борлуулалт маркетинг болон ерөнхий удирдлагын зардалд 619.6 сая төгрөгийг зарцуулж, 410.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлээр борлуулалтын орлого 16.8 хувь буюу 43.5 сая төгрөгийн дутуу биелэлттэй байна. Энэ нь албан газар, орон сууцны цэвэр ус, сувгийн орлого, бохир соролтын орлого биелээгүй, мөн төсвөөс авах татаас 99.0 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Нийт зардал 91.8 хувийн гүйцэтгэлтэй зарцуулагдсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	18,051,473.06	22,073,726.47
1.1.2. Дансны авлага	46,383,510.87	76,512,549.86
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	23,000.0	409.09
1.1.4. Бусад авлага	51,598,295.95	46,650,009.27
1.1.6. Бараа материал	394,035,368.39	547,791,064.40
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	1,223,408.0	1,200,00.00
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	511,315,056.26	694,227,759.09
1.2.1 Үндсэн хөрөнгө	9,357,765,563.47	9,025,486,035.97
1.2.2 Биет бус хөрөнгө	49,268,250.07	1,575,628,250.11
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,407,033,813.54	10,601,114,286.08
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,918,348,869.80	11,295,342,045.17
2.1.1.1 Дансны өглөг	38,210,871.87	29,169,211.63
2.1.1.3 Татварын өр	72,082,627.89	253,498,655.16
2.1.1.4 НДШ-ийн өр		
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	110,293,499.76	282,667,866.79
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2 Өр төлбөрийн нийт дүн	110,293,499.76	282,667,866.79
2.3 Эздийн өмч	1,607,576,940.00	3,222,261,940.00
2.3.1 Төрийн	1,607,576,940.00	3,222,261,940.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	274,491,026.98	274,491,026.98
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	376,926,480.00	376,926,480.00
2.3.9 Хуримтлагдсан ашиг	7,549,060,923.06	7,138,994,731.40
Өмнөх	7,549,060,923.06	7,549,060,923.06
Тайлант үе		-410,066,191.66
2.3.11 Эздийн өмчийн дүн	9,808,055,370.04	11,012,674,178.38
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,918,348,869.80	11,295,342,045.17

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,576,447,268.70	3,944,249,968.44
2	Борлуулалтын өртөг	3,526,529,690.67	3,737,020,991.79
3	Нийт ашиг (алдагдал)	49,917,578.03	207,228,976.65
8	Бусад орлого	2,316,929.89	2,343,337.35
9	Борлуулалт, маркетингийн зардал	240,667,119.02	338,403,371.46
10	Ерөнхий ба удирдлагын зардал	256,534,497.13	281,235,134.20
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-445,364,608.23	-410,066,191.66
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-445,364,608.23	-410,066,191.66
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		

"Онги-Ус суваг" /ТБОНӨӨ/ ХХК-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-445,364,608.23	-410,066,191.66
23.3	Бусад олз (гарз)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,607,576,940.00	274,491,026.98	376,926,480.0	7,549,060,923.06	9,808,055,370.04
2	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
3	2025 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,607,576,940.00	274,491,026.98	376,926,480.0	7,549,060,923.06	9,808,055,370.04
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
5	Залруулсан үлдэгдэл					
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-410,066,191.66	-410,066,191.66
7	Бусад дэлгэрэнгүй орлого					
8	Өмчид гарсан өөрчлөлт	1,614,685,000.00				1,614,685,000.00
9	Зарласан ногдол ашиг					
10	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
11	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,222,261,940.00	274,491,026.98	376,926,480.00	7,138,994,731.0	11,012,674,178.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлтийн нэр	Өмнөх үе	Тайлант үе
1	Мөнгөн орлого дүн	3,963,458,847.38	4,313,341,625.59
1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,574,395,618.52	3,910,567,178.79
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	270,900,000.00	373,610,215.00
	Бусад мөнгөн орлого	118163,228.86	29,164,231.80
1.2	1.2 Мөнгөн зарлагын дүн	3,872,194,811.36	4,172,848,644.87
	Ажиллагчдад төлсөн	1,664,687,895.12	2,023,830,193.87
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	212,026,480.35	347,095,558.23
	Бараа материал худалдан авахад төлсөн	534,559,822.67	351,900,471.82
	Татварын байгууллагад төлсөн	227,580,490.80	232,432,625.37

"Онги-Ус суваг" /ТБОНӨӨ/ ХХК-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Бусад мөнгөн зарлага	344,565,017.41	232,422,724.03
	Ашиглалтын зардалд төлсөн	385,867,898.01	540,131,256.55
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	502,907,207.00	445,035,815.00
	Даатгалын төлбөрт төлсөн		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	91,264,036.02	140,492,980.72
2	2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн +		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн -	185,815,772.70	136,470,727.30
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	185,815,772.70	136,470,727.30
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-185,815,772.70	-136,470,727.30
3	3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн +		
	Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн -		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-94,551,736.68	4,022,253.42
5	Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	112,603,209.73	18,051,473.05
6	Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,051,473.05	22,073,726.47

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	эзлэх хувь
1	Онги Ус Суваг" ХХК" /ТБОНӨӨ	3,735,371,806	3,047,117,068	77%
2	Халаалтын зуух	502,550,504	469,904,511	12%
3	Хужирт	371,603,622	303,576,920	8%
4	Сант	51,780,588	49,685,373	1%
5	Хайрхандулаан	79,602,316	76,309,433	2%
	Орлого дүн	4,740,908,836	3,946,593,306	100%
1	Онги Ус Суваг" ХХК" /ТБОНӨӨ	3,735,371,807	3,357,133,799	77%
2	Халаалтын зуух	502,550,504	484,817,048	11%
3	Хужирт	371,603,622	389,092,867	9%
4	Сант	51,780,588	49,467,277	1%
5	Хайрхандулаан	79,602,316	76,148,507	2%
	Зардал дүн	4,740,908,836	4,356,659,498	100%
	Ашиг алдагдал	-	(410,066,192)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 59.8 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрч аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Залруулсан алдаа:

- Харилцах дансанд андуурч орсон 21 удаагийн 47.8 сая төгрөгийн орлого зарлагыг мөнгөн гүйлгээний тайланд давхар тайлагнасан байгаа нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “иж бүрэн байх”, “оршин байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Балансаас баланст шилжүүлсэн авто машины үлдэх өртөг 11,9 сая төгрөгийн элэгдлийн зардалд шууд хааж нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг буруу хийсэн нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “оршин байх”, “иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй 156.7 сая төгрөгийн зөрчил² илэрч 2 албан шаардлага, 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.2 Албан шаардлага

Аудитын илрүүлэлт:

1. Бараа материалын дараах данснуудад горим сорил хэрэгжүүлэхэд: Эд хариуцагчийн тайлан, орлого зарлагын баримт гарын үсгээр баталгаажуагүй, тайланг тухай бүр гаргуулж нягтлан бодогч хянаж, хүлээн аваагүй, материал зарцуулсан анхан шатны баримт болох, зарлагын баримт, шаардах хуудас дутуу зэрэг зөрчлүүд илэрсэн.

Үүнд: Материал, багаж хэрэгсэл данс-56,1 сая төгрөг, Шатахуун-47,9 сая төгрөг, Авто сэлбэг-10,9 сая төгрөг, Хүнс-7,5 сая төгрөг, нийт 122,5 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын бүрдүүлэлтгүй, хяналтгүй, зарцуулсан байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэх

2. Бараа материалын тооллогыг чанаргүй хийсэн, тооллогын бүртгэлийн дүнг тодруулга тайлангийн үлдэгдэлтэй тулгахад 34.2 сая төгрөгөөр зөрүүтэй, тооллогын комиссын дүнг Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцээгүй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэх

3.3 Зөвлөмж

Аудитын илрүүлэлт:

1. Бараа материалын 16 данстай, зарим дансны нэршил нь НББОУС, журам зааварт нийцсэн нэршилээр нэрлэгдээгүй, бараа материалын ангилал, хуваарилалт хангалтгүй, эмх цэгц муутай байна.

Өгсөн зөвлөмж: 1. Бараа материалын дансны нэр, зориулалтад хамааруулж хөрөнгийн ангиллыг хуваарилах. 2. Энэхүү ангиллаа НББ-ийн программ болон нярвын программдаа өөрчлөлтөө хийлгэх

2. Шилэн дансны цахим сайтад таван сая төгрөгөөс дээш орлогын 68, зарлагын 51 гүйлгээг, өмч хөрөнгө зарцуулсан 18 шийдвэрийг хуульд заасан хугацаанд мэдээлээгүй, хугацаа хоцроосон байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Шатахуун, түлээ нүүрсний эд хариуцагчийн тайланг ерөнхий нягтлан бодогч гаргаж байгаа нь эд хариуцагчийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хэрэгжих боломжгүй болсон байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун, түлээ нүүрсний эд хариуцагчийн ажил үүргийг дотооддоо зохион байгуулж, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөрчлүүдэд үндэслэн “Онги-Ус суваг” /ТБОНӨӨ/ ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого зарлага илүү тайлагнасан.	1	47,830.4			1	47,830.4	1	47,830.4				
Элэгдлийн зардал буруу бүртгэсэн	1	11,956.6			1	11,956.6	1	11,956.6				
Дүн	2	59,787.0	0	0	2	59,787.0	2	59,787.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материал	3	122,483.2			1	122,483.2	2	0				
Тооллого	1	34,196.9			1	34,196.9						
	4	156,680.1	0	0	2	156,680.1	2	0	0	00	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс					
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Хугацаа хоцроосон	1	0							1	0		
Дүн	1	0							1	0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн	0	00	00	00	00	00	00	00	00	0		
Нийт дүн	1	0							1			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 13

6217143681

ИЮА0059 9044094